

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)
А. Нарийн голын хөндийн бууц суурин - 80000 жилийн өмнө **Б. Цагаан агуй - ?**
 А. 730000 жилийн өмнө В. 300000 жилийн өмнө С. 40000 жилийн өмнө
 Д. 12000 жилийн өмнө Е. 8000 жилийн өмнө

2. Дээд палеолитын үед холбогдох Хойд цэнхэрийн агуйн хадны зургийг ямар аргаар зурсан бэ? (2 оноо)
 А. Амьтны загварт урлаг В. Сийлмэл С. Зосон Д. Хадны зураг Е. Хийсвэр

3. Монгол оронд оршин суугчид үйлдвэрлэх аж ахуйд аль үеэс шилжсэн бэ? (1 оноо)
 А. Энеолит В. Палеолит С. Мезолит Д. Неолит Е. Хурлийн үе

4. Тамсагбулагийн суурингаас нэхмэл эдлэлийн багаж мөн бог малын чөмөгт ясан зүү хийж дагалдуулсан эмэгтэй хүний оршуулга олдсон. Үүнийг хэрхэн дүгнэж болох вэ? (2 оноо)
 А. Неолитын үед эмэгтэйчүүдийг л оршуулдаг байжээ.
 В. Неолитын үед үс, ноос ээрч, даавуу нэхэж хувцас хийдэг байжээ.
 С. Неолитын үеэс эхлэн хүмүүс нас барагсдаа оршуулах болжээ.
 Д. Хүмүүсийн дунд эд хөрөнгө, эрх мэдлийн ялгарал байжээ.
 Е. 10000 жилийн тэртээ нэхмэл эдлэл бий болжээ.

5. Хүрэл, түрүү төмрийн үед холбогддог, Монгол нутгаас 1200 орчим олдоод байгаа түүхэн дурсгал аль нь вэ? (1 оноо)
 А. Түүвэр олдвор В. Хиргисүүр С. Дөрвөлжин булш
 Д. Хадны зураг Е. Буган хөшөө

6. Төв Азийн нүүдэлчдийн байгуулсан анхны эзэнт гүрэн аль нь вэ? (1 оноо)
 А. Хүннү В. Сяньби С. Жужан Д. Хятан Е. Их Монгол улс

7. НТӨ IV зуунд хятадын Жао зэрэг ванлигууд нүүдэлчдийн хувцсыг өмсөж, нум сумт морьт цэрэг байгуулжээ. Үүний учир шалтгаан юу вэ? (2 оноо)
 А. Нүүдэлчидтэй амжилттай дайтахын тулд
 В. Хятадын эдийн засаг хямарснаас
 С. Тагнан турших дайн хийхийн тулд
 Д. Жао ванлиг Хүннүгийн хараат болсноос
 Е. Шинэ газар нутгийг байлдан эзлэх зорилгоор

8. Уйгур улс хэний үед цэцэглэн хөгжсөн бэ? (1 оноо)
 А. Буман В. Пэйло С. Моюнчур Д. Чарагуй Е. Таньшихуай

9. Эртний улсуудын мал сүргийн бүтэц өнөөгийн монголчуудтай адил бөгөөд хамгийн цөөн тоотой мал аль нь вэ? (1 оноо)
 А. Хонь В. Тэмээ С. Үхэр Д. Адуу Е. Ямаа



10. Гиюй (Лаошан) шаньюйд Хань улсын ордны тайган Жун Хан хүчин зүтгэж байхдаа “Танай улсын хоол унд, хувцас хунар хятадаас өөр, хараат бус учир хүчирхэг байдаг. Цаашид дассанаасаа давахгүй байхыг зөвлөж байв” гэсэн сурвалжийн мэдээ нь ямар утга санааг илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Нүүдэлчдийн аж ахуйн хөгжил Хань улсаас илүү байсан.
- B. Хүннүгийн аж ахуйн хөгжлийг урагшлуулахгүй байхыг санаархаж байсан.
- C. Эртний хятад хүмүүс нүүдлийн мал аж ахуйд татагдах болсон.
- D. Мал аж ахуй, нүүдэлчдийн үндсэн хэрэгцээг хангаж чадаж байсан.
- E. Хүннү нар Хань улстай хувцас хунар, хоол, идээ ижил байсан.

11. Хүннүд НТӨ III зуун гэхэд Энэтхэгээс ямар шашныг дэлгэрсэн хэмээн үздэг вэ? (1 оноо)

- A. Христийн шашин
- B. Бөөгийн шашин
- C. Манихейн шашин
- D. Лалын шашин
- E. Бурхны шашин

12. Монголын эртний улсуудын соёлоос Сяньби улсын үед аль нь холбогдох вэ? (1 оноо)

1. Их, бага бичиг 2. Ахын дуу 3. Төмөр дөрөө 4. Эсгий ширдэг 5. Хар балгас

- A. 2, 4
- B. 1, 2
- C. 3, 5
- D. 2, 3
- E. 1, 5

13. Татарууд 1003 оны үед Хятаны нөлөөнөөс гарч, бие даасан байдалтай болжээ. Уг оныг зуунд шилжүүлнэ үү. (1 оноо)

- A. XI зууны I хагас
- B. X зууны I хагас
- C. X зууны II хагас
- D. XII зууны I хагас
- E. XI зууны II хагас

14. Эргүнэ гүний домог бичгийн ямар эх сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн бэ? (2 оноо)

- A. Лу.Алтан товч
- B. Монголын нууц товчоо
- C. Судрын чуулган
- D. Ертөнцийг байлдан дагуулагчийн түүх
- E. Дорно этгээдэд зорчсон тэмдэглэл

15. Чингис хааны өмнөх үеийн Монголчуудад холбогдох ойлголтыг зөв тохируулна уу. (2 оноо)

- 1. Тайш, сэцэн, мэргэн
- 2. Хүрээ
- 3. Талын малчин, ойн анчин
- a. Нийгмийн зохион байгуулалт
- b. Нийгмийн давхраажилт
- c. Аж ахуй
- A. 1c 2a 3b
- B. 1a 2b 3c
- C. 1b 2c 3a
- D. 1b 2a 3c
- E. 1a 2c 3b

16. Их Монгол улсын хэмжээнд хууль ёсыг чандлан сахиулж, аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий их заргачийн тушаалд хэнийг томилсон бэ? (1 оноо)

- A. Үсүн өвгөн
- B. Го ван Мухулай
- C. Цагадай
- D. Хубилай
- E. Шихихутуг

17. 1211 онд Чингис хаан Алтан улс руу довтлох болсон шалтгаан юу вэ? (1 оноо)

- A. Эцэг өвгөдийн гэрээсийг биелүүлэх, аюулгүй байдлаа хангах учир
- B. Аян дайны үед баруун гар болох холбоотны үүргээ биелүүлээгүй учир
- C. 450 худалдаачдыг хөнөөж, элчийг хороож доромжилсон учир
- D. Төрийн эрхэнд гарсан Найманы Таян ханы хүү Хүчүлүгийг дарах учир
- E. Алтан улс, Тангуд улстай Монголын эсрэг гэрээ байгуулсан учир



18. Чингис хааны дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг ялгана уу.

(2 оноо)

1. Их Монгол улсыг байгуулсан.
2. Торгоны замын үүрэг өндөр түвшинд хүрсэн.
3. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоосон.
4. Мянгатын системийг буй болгов.
5. Өрнө, дорнын хооронд худалдаа, соёлын харилцаа хөгжив.
6. Хархорум хот дэлхийн нийслэл болох үндэс тавигдав.

A. 1, 2, 3 B. 2, 3, 5 C. 3, 4, 6 D. 2, 3, 6 E. 1, 3, 4

19. 1229 онд Өгэдэйг Хэрлэний Хөдөө аралд хаан ширээнд залжээ. Чингисийн хэдэн он бэ? (1 оноо)

- A. Чингисийн 67 он B. Чингисийн 68 он C. Чингисийн 70 он
D. Чингисийн 40 он E. Чингисийн 23 он

20. 1380 онд Мин улсын их цэрэг Монголын гүнд нэвтэрч ямар хотыг эвдлэн сүйтгэж шатаасан бэ? (1 оноо)

- A. Хар балгас B. Шанду C. Ауруг D. Хархорум E. Луут

21. Мин улсын зүгээс монголчуудын худалдаа хийх хүсэлтийг хааж боогдуулж байв. Монгол улстай худалдаа хийхдээ зөвхөн нас залуу агт морьд, үржлийн насны гүүгээр арилжаа хийх “адуун засгийн бодлого” явуулдаг байжээ. Үүний учир шалтгаан юу вэ? (2 оноо)

- A. Нүүдэлчдийг нүүдэлчдээр нь цохиулах хятадын төрийн уламжлалт бодлогыг явуулахын тулд
B. Монголчуудын адуун сүргийн бүтцийг сайжруулж, өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд
C. Монголчуудад туслах замаар адуу худалдан авч, хүчээ зузаатгахын тулд
D. Монголчуудыг уулгалан довтолж, асуудлыг хүчээр шийдвэрлэх байдлыг зогсоохын тулд
E. Монголчуудын цэрэглэх чадварыг бууруулж, өөрсдийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд

22. XVII зууны үеийн бие даасан улсуудаас **Ашихай, Түшээт хан, баруун гар** зэрэг ойлголтууд нь ямар улсад холбогдох вэ? (1 оноо)

- A. Хотгойд улс B. Өвөр Монгол
C. Ойрадын хаант улс D. Хошууд улс E. Халх Монгол

23. 1640 онд Халх, Ойрад, Халимаг, Хошуудын эрх баригч 28 ноён язгууртнууд ямар нэртэй газар “Их цааз”-ыг баталсан бэ? (2 оноо)

- A. Ар элстэй B. Долоон нуур C. Хөх хот
D. Тарвагатайн улаан бураа E. Хүрэн бэлчир

24. 1586 онд Абтай сайн хан Очирваань бурхан, ном судар тэргүүтнийг залж ямар хийдийг байгуулсан бэ? (1 оноо)

- A. Эрдэнэзуу хийд B. Амарбаясгалант хийд
C. Манзуширын хийд D. Шанхын хийд E. Хөгнө Тарнын хийд



25. XVII зуунаас монголчууд бүх нийтээр шарын шашинд орсон шалтгаанд аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)

- A. Монгол, Төвөд хоёр нэгдэх зорилготой байсан тул шарын шашинд орсон
- B. Төвөдүүд улс төр, эдийн засаг, цэргийн дэмжлэг авах гэж шашнаа дэлгэрүүлсэн
- C. Манжууд Монголчуудын дайнч байдлыг бууруулахын тулд шашныг дэмжсэн
- D. Монголын язгууртнууд шарын шашныг ашиглан нэр хүндээ өсгөхийг зорьсон
- E. Монголын ард түмэн байнгын дайн самуунаас залхаж, шинэ шашныг хүлээн авсан

26. XVI-XVII зуунд Монголчуудын зохиосон бичиг үсгийг цаг хугацаагаар нь эхлэлээс төгсгөл рүү зөв эрэмбэлсэн хэсгийг сонгоно уу. (2 оноо)

1. Соёмбо үсэг	2. Тод үсэг	3. Али гали
----------------	-------------	-------------

- A. 3, 1, 2 B. 1, 2, 3 C. 3, 2, 1 D. 2, 1, 3 E. 1, 3, 2

27. Манж Чин улсын эрхшээлд орсон Монголын хаант улсуудыг зөв ялгасан хэсгийг сонгоно уу. (1 оноо)

Манж Чин улс	1	Буриад Монгол
	2	Өвөр Монгол
	3	Зүүнгар
	4	Халимаг Монгол
	5	Халх Монгол

- A. 2, 4, 5 B. 1, 2, 3 C. 3, 4, 5 D. 2, 3, 5 E. 1, 3, 5

28. Лигдэн хаан Цахар түмнээ монгол уламжлалаар зүүн, төв, баруун гурван түмэн болгон хувааж, монголчуудыг бурхны шашны үзэл суртлаар нэгтгэхийг зорьж байсан нь ямар бодлогод хамаарах вэ? (2 оноо)

- A. Адуун засгийн бодлого
- B. Дайчин төрөөр нэгтгэх бодлого
- C. Шинэ засгийн бодлого
- D. Шинэ эргэлтийн бодлого
- E. Тайван төрөөр нэгтгэх бодлого

29. Баруун зүг Ижил мөрний адгаар Ойрад монголчуудын байгуулсан улсыг хожим юу гэж нэрлэх болсон бэ? (1 оноо)

- A. Халимаг
- B. Буриад
- C. Хошууд
- D. Торгууд
- E. Дөрвөд

30. Сөнөдийн Тэнгис ван буруугаа хүлээж Манжид хэдэн онд бууж өгсөн бэ? (1 оноо)

- A. 1639
- B. 1646
- C. 1648
- D. 1640
- E. 1636

31. 1688 оны Халх, Ойрадын дайны гол хор уршиг аль вэ? (2 оноо)

- A. Халхын нутаг Галдан хааны мэдэлд орсон.
- B. Халх Монголыг Манжид дагаар ороход хүргэсэн.
- C. Монгол Төвөдийн харилцаа муудахад хүргэсэн.
- D. Халх, Орос улсын дайн тулааныг зогсоосон.
- E. Монгол цэргийн хүчин чадлыг бууруулсан.



32. XIX-XX зууны эхэн үеийн Халхын 4 аймгийг газар зүйн байршлаар нь зүүнээс баруун руу зөв эрэмбэлнэ үү. (2 оноо)

1. Сайн ноён аймаг 2. Түшээт хан аймаг 3. Засагт хан аймаг 4. Сэцэн хан аймаг

A. 1, 2, 3, 4 B. 4, 2, 1, 3 C. 2, 3, 1, 4 D. 4, 1, 2, 3 E. 2, 4, 1, 3

33. Монголчууд “үндсийг таслах, шашныг устгах” хэмээн ямар бодлогыг үзэж байсан бэ? (1 оноо)

A. Тайван төрөөр нэгтгэх бодлого B. Шинэ эргэлтийн бодлого
C. Шинэ сэргэлтийн бодлого D. Шинэ засгийн бодлого E. Шинэчлэлийн бодлого

34. Дараах үйл явдлыг утгаар нь зөв харгалзуулна уу. (1 оноо)

a	1900	1	Монгол улс автономит болов.
b	1912 оны 1 сар	2	Бадамдорж, Цэрэн-Очир нарыг Орос улсад тусламж хүсэхээр илгээв.
c	1915	3	Монгол цэргүүд Улиастайг чөлөөлөв.

A. a2 b3 c1 B. a1 b2 c3 C. a3 b2 c1 D. a3 b1 c2 E. a2 b1 c3

35. 1911 оны Монгол улсын засгийн газрын цэргийн яамны сайд хэн бэ? (1 оноо)

A. Э.Намсрай B. М.Ханддорж C. Г.Цэрэнчимэд D. Г.Чагдаржав E. С.Гомбосүрэн

36. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон цагаан алт, очир алмас, эрдэнийн чулууны орлогын хэдэн хувийг татварлах вэ? (1 оноо)

A. 5-10% B. 10-15% C. 20-30% D. 20-50% E. 30-60%

37. 1921 оны хувьсгалын түүхэн зүтгэлтнүүдийг зөв ялгасан хэсгийг сонгоно уу. (1 оноо)

1921 оны хувьсгалын удирдагчид	1	Гүн Хайсан
	2	С.Данзан
	3	С.Зориг
	4	Л.Лосол
	5	Т.Намнансүрэн
	6	Ж.Батмөнх

A. 5, 6 B. 1, 3 C. 2, 4 D. 2, 1 E. 3, 4

38. 1921 оны хувьсгалд холбогдох үйл явдлыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Нууц бүлгэмүүд байгуулагдав.
2. Ардын засгийн газрыг байгуулав.
3. Барон Унгерн Нийслэл хүрээг чөлөөлөв.

A. 1, 2, 3 B. 3, 2, 1 C. 2, 3, 1 D. 1, 3, 2 E. 2, 1, 3

39. 1921 оны намар Хасбаатар, Дамбадорж нарын удирдсан цэргүүд 42 хоног хаана бүслэгдэн байлдсан бэ? (1 оноо)

A. Толбо нуур B. Улиастай C. Хиагт D. Ховд E. Нийслэл хүрээ



40. ЗСБНХУ-ын гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринээс Монгол дахь бүрэн эрхт төлөөлөгч Никифоровт өгсөн заавраас “БНМАУ нь Хятадын суверенитетийн дор автоном байх хэлбэрийг бид тунхаглах боловч хэрэг дээрээ улс төр, эдийн засгийн байгууллын хувьд Монголыг Зөвлөлт маягийн хэлбэрт ойртуулахын тулд бид ажиллана” хэмээх сурвалжийн мэдээнээс Зөвлөлт Орос улсын Монголын талаар баримталж буй бодлогыг тодорхойлно уу. (2 оноо)
- А. ЗОУ Хятадтай харилцахын тулд Монголыг ашигладаг байжээ
В. ЗОУ Монголыг улс төр, эдийн засгийн хувьд Хятадаас хамгаалах
С. ЗОУ Монголыг улс төр, эдийн засгийн талаар Хятадад уусгах
D. ЗОУ хүч сул байсан тул Хятадын талд зогсдог байжээ
E. ЗОУ Монголыг улс төр, эдийн засгийн хувьд өөрийн нөлөөндөө байлгах
41. Анхдугаар Үндсэн хуулиар улсын нийслэлийг хэрхэн өөрчилсөн бэ? (1 оноо)
- А. Хархорум В. Нийслэл хүрээ
С. Их хүрээ D. Улаанбаатар E. Өргөө
42. 2024 онд Монгол улс Бүгд найрамдах засаглалд шилжиж, анхдугаар үндсэн хуулиа баталсны хэдэн жилийн ой тохиож байна вэ? (1 оноо)
- А. 113 жилийн ой В. 84 жилийн ой
С. 100 жилийн ой D. 103 жилийн ой E. 90 жилийн ой
43. 1940 он гэхэд мал сүргийн тоо 26,204 мянгад хүрч, 1932 оныхоос 39.1 хувиар өссөн нь ямар бодлогын үр дүн бэ? (2 оноо)
- А. Эдийн засгийн үндсэн бодлого В. Шинэ эргэлтийн бодлого
С. Шинэчлэлийн бодлого D. Шинэ засгийн бодлого
E. Шинэ сэргэлтийн бодлого
44. Монгол хүн бүр эх орон, тусгаар тогтнолдоо үнэнч гэдгээ нотлон харуулсан бүх нийтийн санал хураалт хэзээ болсон бэ? (1 оноо)
- А. 1924.11.26 В. 1945.11.26
С. 1911.12.29 D. 1945.10.20 E. 1921.7.11
45. 1960-аад оноос Монголд улс төрийн ямар дэглэм тогтсон бэ? (1 оноо)
- А. Цэргийн В. Тоталитар
С. Ардчилсан D. Бүгд найрамдах E. Авторитар
46. 1979 оны МАХН-ын Төв Хорооны тогтоолд “Хүн бүр бага балчраасаа эхлэн туйлын аж ахуйч, арвич хямгач, социалист өмчийн эс ширхэг бүрийг алхам тутамдаа нүдлэн хамгаалагч, хөдөлмөрийг бишрэн шүтэгч байх ёстой” хэмээх сурвалжийн мэдээ түүхэн ямар үйл явдлыг илэрхийлж байна вэ? (1 оноо)
- А. Соёлын довтолгоо В. Намын эсрэг бүлэглэл С. Атрын аян
D. Сэхээтний төөрөгдөл E. Нэгдэлжих хөдөлгөөн
47. Хүйтэн дайны үеийн сэргэлдэгч талуудад орох улсууд аль нь вэ? (2 оноо)
- А. Социалист орнууд- Монгол, ЗХУ** **В. Капиталист орнууд- ?**
- А. Баруун Герман, Хятад В. Баруун Герман, Вьетнам
С. Дани, Умард Солонгос D. Франц, Өмнөд Солонгос E. Бельги, Польш



48. Өгөгдлийг ашиглаж зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)
(Олноо өргөгдсөний 14 он+Ардын хувьсгалын 71 жилийн ой):2+3=?
 А. 1976 онд Атрын II аян өрнөв. В. 1945 оны Чөлөөлөх дайн болов.
 С. 1939 оны Халх голын дайн болов. D. 1981 онд Монгол хүн сансарт нисэв.
 E. 1961 онд Монгол улс НҮБ-д элсэв.
49. Монголын Ардчилсан холбооны 10 гишүүн улс төрийн өлсгөлөнг хэзээ зарласан бэ? (1 оноо)
 А. 1990.3.12 В. 1990.3.23 С. 1990.3.7 D. 1992.1.13 E. 1990.3.2
50. 1990 оны ардчилсан хувьсгал гарах болсон учир шалтгааныг зөв харгалзуулна уу. (2 оноо)
1. Дотоод шалтгаан
 - a. ЗХУ-д өөрчлөн байгуулалт эхлэв.
 - b. Нэг намын дарангуйлал, захиран тушаах дэглэм тогтов.
 2. Гадаад шалтгаан
 - c. Социалист систем задрав.
 - d. Олон ургалч үзлийг хаан боогдуулж байв.
- А. 1a,c 2b,d В. 1b,d 2a,c
 С. 1b,a 2c,d D. 1d,a 2c,b E. 1c,d 2a,b
51. Монгол улсын хоёр дахь ерөнхийлөгч хэн бэ? (1 оноо)
 А. П.Очирбат В. Н.Энхбаяр С. Ц.Элбэгдорж D. Н.Багабанди E. Х.Баттулга
52. 1992 оны Үндсэн хуулийн дагуу хууль тогтоох байгууллага аль нь вэ? (1 оноо)
 А. Ерөнхийлөгч В. Засгийн газар С. Шүүх
 D. Үндсэн хуулийн цэц E. Улсын Их Хурал
53. Чингис хааны мэндэлсний 840 жилийн ой хэдэн онд тохиосон бэ? (1 оноо)
 А. 2002 он В. 2006 он С. 2022 он D. 2009 он E. 1990 он
54. Өгөгдлийг зөв тохируулна уу. (2 оноо)
- | | | | |
|---|---------|---|---|
| a | 1992 он | 1 | Монголын төр хэлмэгдэгсдийн үр хүүхэд ач нараас уучлал гуйв. |
| b | 1993 он | 2 | Бурхан багшийн чандрыг Монголд залж, Буддын шашны тэргүүн Далай лам Монголд айлчлав. |
| c | 1996 он | 3 | Албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэлийг хангах ажлыг эрчимжүүлэх тухай тогтоол гаргав. |
- А. a2 b3 c1 В. a1 b2 c3 С. a3 b2 c1 D. a3 b1 c2 E. a2 b1 c3
55. 2014 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ? (1 оноо)
 А. Япон улсын ерөнхий сайд Тошику Кайфу айлчлав.
 В. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалыг батлав.
 С. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.
 D. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.
 E. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав.
56. Байгаль орчны тэнцвэрийг хадгалж, байгалийн аюулт үзэгдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах мөн хүний эрүүл оршин амьдрах нөхцөлийг баталгаажуулах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ? (1 оноо)
 А. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
 В. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах
 С. Дотоод аюулгүй байдлыг хангах
 D. Хүний аюулгүй байдлыг хангах
 E. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо
Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

2.1 Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын байгуулагдсан он цагийг зөв тохируулна уу. (6 оноо)

- | | |
|-----------|---------------------------|
| a. Хүннү | 1. X зууны I хагас |
| b. Жужан | 2. 745 |
| c. Сяньби | 3. НТӨ III зууны II хагас |
| d. Уйгур | 4. 555 |
| e. Түрэг | 5. 156 |
| f. Хятан | 6. IV зууны I хагас |

2.2 Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох он цагуудыг хамаарах үйл явдлуудтай нь зөв тохируулна уу. (6 оноо)

- | | |
|---------|---|
| a. 1256 | 1. Хубилай, Аригбөх хоёр хаан ширээнд суув. |
| b. 1260 | 2. Алтан орд улс мөхөв. |
| c. 1271 | 3. Хубилай улсын нэрийг Их Юань хэмээн өөрчлөв. |
| d. 1363 | 4. Цагадайн улс задарч эхлэв. |
| e. 1368 | 5. Хүлэгү Ил хаант улсыг байгуулав. |
| f. 1480 | 6. Их Юань улсын сүүлчийн хаан эх нутагтаа буцав. |

2.3 XIV-XVI зууны үеийн түүхэн зүтгэлтнүүдийг холбогдох үйл явдалтай нь зөв тохируулна уу. (6 оноо)

- | | |
|-------------------------|--|
| a. Элбэг нигүүлсэгч | 1. Гар газар, хөл хөсөр байсан үе. |
| b. Эсэн тайш | 2. Төв засгийн газар байгуулав. |
| c. Батмөнх даян | 3. Хилсээр түшмэл Хуухайг хороов. |
| d. Түмэн засагт | 4. Батмөнхийг бусад ноёдын дэмжлэгтэйгээр хаан ширээнд суулгав. |
| e. Алтан хан | 5. Мин улсын Инзүн хааныг олзлов. |
| f. Мандухай сэцэн хатан | 6. Цахар хийгээд Түмэд тэргүүтэн хэсэг бөлөг Монголыг захирсан хан байв. |

2.4 Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцлийн арга хэлбэрүүдийг тохирох ойлголттой нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------------|---|
| a. Зэвсэгт бослого | 1. Сөнөдийн Тэнгис ван харьяат ардын хамт |
| b. Дугуйлангийн хөдөлгөөн | 2. Шилийн сайн эрс |
| c. Ганц нэгээрээ тэмцэх | 3. Тэмцлээ бичгээр илэрхийлэв |
| d. Бөөнөөрөө оргон нүүх | 4. Харуул, өртөө |
| e. Алба хаях | 5. 1755-1758 оны бослого |
| f. Заргын бичиг | 6. Өвөр Монголын Ордосын хошуудад өрнөв |

